

ЦЭВЭР УСНЫ ХАНГАМЖИЙН 20 .. ОНЫ СУДАЛГАА

1.ХАЯГИЙН ХЭСЭГ

	код
Дүүргийн нэр:	
Хорооны дугаар:	

1. Хорооны Засаг дарга нь жил бүрийн 12-р сарын 20-ны дотор бүртгэлийг цахим дүүргийн ЗДТГ-т хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хянаж, нэгтгэн нь 12-р сарын 25-ны дотор УБ хотын ЗАА цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Ундны усны эх үүсвэр	МД	Өрхийн тоо	Хүн амын тоо
А	Б	1	2
Бүгд мөр 1= мөр(2+9+15)	1		
Шаардлага хангасан ундны усны эх үүсвэр, мөр 2= мөр(3:5+7:8)	2		
Ус хангамжийн шугам сүлжээ	3		
Ус түгээх байр	4		
Хамгаалсан худаг	5		
Лабораторийн шинжилгээтэй худаг	6		
Хамгаалсан булаг	7		
Зөөврийн усны үйлчилгээ	8		
Шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэр мөр 9= мөр(10:14)	9		
Хамгаалаагүй худаг	10		
Хамгаалаагүй булаг	11		
Ус зөөврийн ердийн хөсөг	12		
Хурын ус	13		
Усны ил эх үүсвэр	14		
Бусад эх үүсвэр мөр 15= мөр(16)	15		
Савласан ус	16		

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Цэвэр усны хангамжийн 20... оны судалгааны маягт (ЭАБ-7) - ыг нөхөх заавар

Хорооны Засаг дарга "Хүн ам, өрхийн бүртгэлийн сан болон худгийн жилийн бүртгэл зэргийг үндэслэн судалгааг гаргана.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил: Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө.

Хорооны дугаарыг "Хүн ам"-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон www.ubstat.mn цахим хуудсаас харах боломжтой.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

1 дүгээр баганад: Тухайн хорооны өрхийн тоог бичнэ.

2 дугаар баганад: Тухайн хорооны хүн амын тоог бичнэ.

1 дүгээр мөрийн дүн нь 2, 9, 15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2 дугаар мөрөнд: Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангадаг өрх, хүн амын тоог нөхнө. 2 дугаар мөрийн дүн нь 3, 4, 5, 7, 8 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

3 дугаар мөрөнд: Ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон өрх, хүн амын тоог нөхнө. **Ус хангамжийн шугам сүлжээ** гэж төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан хэрэглэгчийг усаар найдвартай, тасралтгүй хангадаг системийг хэлнэ.

4 дүгээр мөрөнд: Ус түгээх байрнаас усны хэрэгцээгээ хангадаг өрх, хүн амын тоог нөхнө. **Ус түгээх байр** гэж стандартын шаардлага хангасан ундны усаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон ус түгээх байрыг хэлнэ.

5 дугаар мөрөнд: Хамгаалсан гүний худгаас усны хэрэгцээгээ хангадаг өрх, хүн амын тоог нөхнө. **Хамгаалсан худаг** гэж гадаргын урсац худагт орохоос сэргийлж өндөрлөсөн, бетон бүүрэг; мал амьтан, хог унахаас хамгаалсан ам таглаа бүхий худгийг хэлнэ.

6 дугаар мөрөнд: Лабораторийн шинжилгээтэй худгаас усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө.

7 дугаар мөрөнд: Хамгаалсан булгаас усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө. **Хамгаалсан булаг** гэж гадны нөлөөнд автах гадаргын урсац орохоос хамгаалж тоосго буюу бетон хийцээр битүүлсэн ус авах зориулалтын хоолой болон ариун цэврийн хамгаалалтын бүс бүхий усны эх үүсвэрийг хэлнэ.

8 дугаар мөрөнд: Зөөврийн усны үйлчилгээнээс усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө. **Зөөврийн усны үйлчилгээ** гэж усыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээж борлуулах үйлчилгээг ойлгоно.

9 дүгээр мөрөнд: Шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангадаг өрх, хүн амын тоог нөхнө. 9 дүгээр мөрийн дүн нь 10, 11, 12, 13, 14 дүгээр мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

10 дугаар мөрөнд: Хамгаалаагүй худгаас усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө.

Хамгаалаагүй худгийг дараах нөхцөлтэй байвал хамгаалаагүй худаг гэж үзнэ. Үүнд:

1. Худагт гадаргын урсац орохоос хамгаалаагүй.

2. Худагт мал, амьтан, хог унахаас хамгаалах ам таглаа муутай.

11 дүгээр мөрөнд: Хамгаалаагүй булгаас усны хэрэгцээгээ хангадаг өрх, хүн амын тоог нөхнө. **Хамгаалаагүй булаг** гэж гадаргын урсацаас хамгаалж битүүлээгүй мал, амьтан орох боломжтой булгийг ойлгоно.

12 дугаар мөрөнд: Ус зөөврийн ердийн хөсгөөс усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө.

Ус зөөврийн ердийн хөсөг гэж ус зөөврийн зориулалтын авто тээврээс бусад төрлийн ус зөөх хөсгийг ойлгоно. Энэ нь усыг үхэр, морь, тэмээн тэрэг болон бусад төрлийн хэрэгслээр зөөвөрлөн түгээх үйлчилгээг гүйцэтгэхийг юм.

13 дугаар мөрөнд: Хурын уснаас усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө. Хурын ус гэж бороо, цасны усыг дээвэр ба газрын гадаргуугаас цуглуулж, нөөцлүүрт хадгалсан усыг хэлнэ.

14 дугаар мөрөнд: Усны ил эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө.

Усны ил эх үүсвэр гэж гол мөрөн, нуур, тойром, цөөрөм, голын салаа, татуурга болон усалгааны сувгаас шууд авсан усыг хэлнэ.

15 дугаар мөрөнд: Бусад эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө. 15 дугаар мөрийн дүн нь 16 дугаар мөрийн дүнтэй тэнцүү байна.

16 дугаар мөрөнд: Савласан уснаас усны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, хүн амын тоог нөхнө.

Савласан ус гэж унд ахуйн хэрэгцээндээ ус хангамжийн шаардлага хангасан эх үүсвэрээс, ариун цэврийн болон хадгалалтын горимыг мөрдөж үйлдвэрлэгдсэн савласан усыг хэрэглэж байвал шаардлага хангасан ундны усны эх үүсвэр гэж ойлгоно. Дээрх нөхцөлийг хангаагүй савласан усыг шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэр гэж үзнэ.